



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 45, 3 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 34 16 74, Факс: (976-11) 34 30 61,
Цахим шуудан: info@ubedn.mn, Цахим хуудас: www.tog.mn

2024.11.21 № 1/2059
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Манай компаниас зарлагдсан УБЦТС/20240102243 дугаартай “Кабелийн гэмтэл тодорхойлох, оношлох, урьдчилан сэргийлэх шинжилгээ хийх явуулын иж бүрэн лаборатори, багаж, засвар үйлчилгээ” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт ирүүлсэн тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна.

Тодруулга 1:

“Кабелийн гэмтэл тодорхойлох, оношлох, урьдчилан сэргийлэх шинжилгээ хийх явуулын иж бүрэн лаборатори, багаж, засвар үйлчилгээ” энэхүү тендерт оролцохдоо бичиг баримтыг 1 багцаар бүрдүүлэх үү? 2 багцаа тусад нь бүрдүүлэх үү?

Хариулт 1:

Багцтай тендер шалгаруулалтын хувьд багц тус бүрд үнэлгээ хийгдэх тул багц тус бүрээр нь тендерийн баримт бичгийг бэлдэж ирүүлнэ. Оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадална.

Тодруулга 2:

Тендерийн санхүү чадавхид зааснаар дансны үлдэгдлийн баталгааны дүн тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх уу? Тендер нээсэн өдөр дансанд байршиж байх уу?

Хариулт 2:

Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласанаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй эсэх талаарх лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй. Тендер зарласан өдрөөс хойшхи дансны үлдэгдлийг түргэн хөрвөх санхүүгийн чадавх гэж тооцно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



К.ЭРДЭНЭБАЯР